

ГАРЧИГ

2–3 “Эрдэнэс–тавантолгой” ХК-ийг анхдагч зах зээл дээр амжилттай арилжаалах нь

3–6 Зохицуулалтын мэдээ

7–8 Хамтын санхүүжилт /Шинээр бизнес эрхлэгчид хөрөнгө татан төвлөрүүлэхийн тулд банк болон томоохон санхүүгийн институт, эхлэлийн үйл ажиллагааг дэмжих сангаас (venture capital fund) дэмжлэг авдаг байсан бол хамтын санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглан сая сая хөрөнгө оруулагчид, хандивлагчдаас онлайн платформоор дамжуулан хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой болсон байна./

9–10 Зээлийн зах зээлд гарч буй технологийн дэвшил

11–13 Санхүүгийн хүртээмжийн үндэсний стратегийг боловсруулах нь: олон улсын туршлага

14–15 Танилцуулга /GIZ (Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit) буюу Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны салбарт туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг Германы хөгжлийн агентлаг юм. /

16 Өргөн дуран

16–17 Зохицуулалтын сэндрокс үйлчилгээний хэлбэр

18–22 Зах зээлийн мэдээ

23 Олон улсын даатгалын зах зээлийн чиг хандлага /DELOITTE/

ЗОХИЦУУЛАЛТЫН СЭНДБОКС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР

Өнөө үед ухаалаг гар утасны хэрэглээний өсөлт болон мэдээллийг боловсруулах шинэ үр дүн бүхий аргууд бидний амьдралд нэвтэрснээр санхүүгийн салбарт инновацийг нутагшуулах нөхцөл, суурийг бий болгоод байна. Санхүүгийн зах зээлд 2014 оноос “Финтек” – санхүүгийн уламжлалт үйлчилгээг хүргэх инновацийн шийдлүүдийн талаар яригдаж эхэлсэн.

Цахим худалдааны талаарх бидний ойлголтыг Amazon, Aliexpress нар өөрчилсөн бол Airbnb-г үүсгэн байгуулагч нар үр дүнтэй, эрсдэл багатай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн зах зээлийг бий болгож, харин Uber болон Яндекс такси нар нь таксины үйлчилгээг танигдахын аргагүй болтол нь өөрчлөөд байна. Үүнтэй нэгэн адилаар санхүүгийн зах зээлд crowdfunding, P2P зээл гэх мэт цоо шинэ бизнесийн загварууд, хэрэглэгчтэй харилцах шинэ механизмууд (технологид суурилсан тусгай операторын тусламжтайгаар) бий болсноор хэрэглэгчийн хүлээлт болон хандлага огцом өөрчлөгджээ.



Гэвч санхүүгийн зах зээлийн зохицуулалтууд нь технологийн шинэчлэлийг хурдан хугацаанд хүлээн авч, өөрчлөгдөхөд төдийлөн бэлэн бус байдаг байна.

Шинэ бизнесийн загвар, бүтээгдэхүүн болон үйлчилгээг бий болгох нь олон удаагийн оролдлого, туршилтын арга дээр суурилдаг. Цорын ганц зөв шийдлийг олохын тулд компаниуд олон зуун аргачлалыг тестэлдэг билээ. Үүний үр дүнд өнөөг хүртэл өөрийн уян хатан чанараа алдаагүй хяналт, зохицуулалтууд нь шинэчлэлийг хийгчид буюу инновацийн компаниудад асар их эрсдэлийг авчирдаг. Инновацийн компаниудын технологийн шинэчлэлийн дүнд санхүүгийн уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулагдсан хяналт, зохицуулалтын хүрээнд тогтоосон хэм хэмжээ зөрчигдсөнөөс тэдгээр нь зохицуулагчийн зүгээс холбогдох арга хэмжээ авахуулах эрсдэлтэй учирдаг. Учир нь эдгээр зохицуулалтуудыг боловсруулах үед орчин үеийн технологи, бүтээгдэхүүн, бизнесийн загвар аль аль нь байгаагүй байв.

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хамтын санхүүжилт гэдэг нь онлайн платформоор дамжуулан шинэ санаачилга, бүтээгдэхүүн, төсөл, зээлийг санхүүжүүлэх зорилгоор хувь хүн, аж ахуй нэгж байгууллагаас хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагаа юм. Шинээр бизнес эрхлэгчид хөрөнгө татан төвлөрүүлэхийн тулд банк болон томоохон санхүүгийн институт,

эхлэлийн үйл ажиллагааг дэмжих сангаас (venture capital fund) дэмжлэг авдаг байсан бол хамтын санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглан сая сая хөрөнгө оруулагчид, хандивлагчдаас онлайн платформоор дамжуулан хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой болсон байна.



Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

- 📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.
- ☎ 976 51 261611
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.gov.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📧 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба



Санхүүгийн зохицуулах хорооны
Үнэт цаасны газрын зөвлөх, доктор
Кү Жасам

Доктор Кү Жасам: “ЭРДЭНЭС–ТАВАНТОЛГОЙ” ХК–ИЙГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АМЖИЛТТАЙ АРИЛЖААЛАХ НЬ

Монгол орон бол байгалийн асар их баялагтай, уул, уурхайн үйлдвэрлэл хөгжих арвин боломж бололцоотой улс орон юм. Статистик баримтаас дурдвал, Монголын уул уурхайн салбар нь ДНБ–ний 22 хувь, гадаадын хөрөнгө оруулалтын 72 хувь, аж үйлдвэрлэлийн салбарын 74 хувь, экспортын 90 хувийг эзэлж байгаа бөгөөд “key industry” буюу стратегийн хувьд маш өндөр ач холбогдолтой салбар.

Азийн хөгжлийн банкнаас гаргадаг статистикт Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)–д эзлэх урсгал дансны тэнцэл 2018 онд –6.3 хувь байхаар таамаглсан байдаг бол –8.9 хувь болж буурсан. Харин 2019 оны байдлаарх таамаглсан дүн –7.0 хувь байсан нь одоогийн байдлаар –8.5 хувь болж буураад байна. Энэ нь юуг илэрхийлээд байна вэ гэхээр Монгол Улсын урсгал дансны алдагдал бодит байдал дээр таамаглснаас доогуур байгаа бөгөөд өнөө үед гадаадын хөрөнгө оруулалт нэн чухал шаардлагатай байгааг тодотгож байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын Монголд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэх нь урсгал дансны алдагдлыг бууруулах маш том хөшүүрэг болж өгнө.

Монгол Улсын хувьд гадны хөрөнгө

оруулагчдыг татах нэгэн том гарц нь уул уурхайн салбар. Уул уурхайн салбарыг амжилттай хөгжүүлж, тус салбарт үйл ажиллагаа явуулах үйлдвэрлэлийн үйл ажилаагаа зөв гаргалгаа гарган дэмжин сайжруулах нь цаашдын эдийн засгийн өсөлтөд маш өндөр эерэг нөлөөтэй.

Монгол Улсын уул уурхайн салбарыг хөгжүүлэх буюу салбарын баялагийг эргэлтэд оруулах богино хугацаанд болон урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой 2 арга зам бий. Хамгийн эхний болоод богино хугацаандаа хэрэгжүүлэх арга зам бол “Эрдэнэс–Тавантолгой” ХК–ийг анхдагч зах зээл дээр арилжих явдал. Учир нь тус компанийн 14.5 хувийг иргэд эзэмшиж байгаа ч хувьцаагаа арилжаалах боломжгүй нөхцөл байдалд байгаа. Иймд, компанийн хувьцааг ашигтай замаар эргэлтэд оруулах нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ юм.

Компанийн хувьцааг хамгийн ашигтай байдлаар анхдагч зах зээлд арилжаалах арга зам бол дотоодын зах зээл дээр IPO хийсний дараагаар “Depository Receipt” (DR) буюу хадгаламжийн бичиг гарган гадны хөрөнгийн бирж дээр давхар арилжаалах явдал. IPO–г дотоодын зах зээлд анхлан хийх нь хамгийн

чухал, учир нь хувьцааг гадны анхдагч зах зээл дээр анхлан арилжих нь иргэдийн эрх ашгийг хохироож, хувьцаагаа арилжих боломжгүй нөхцөлд оруулна.

Хадгаламжийн бичгийг гаргах нь нэг талаараа дотоодын болон гадны зах зээл дээр хувьцаа зөрөөтэй үнээр арилжигдах нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай. Учир нь, Монголын хөрөнгийн зах зээлийн хувьцааны арилжааны хөрвөх чадвар маш бага учраас дотоодын зах зээл дээрх хувьцааны үнэ унах нөхцөлийг бүрдүүлдэг. Харин нөгөө талд гадаадын хөрөнгийн бирж дээрх яг ижил компанийн хувьцаа өсөх хандлагатай байдаг. Уг асуудлыг “green shoe option” аргыг ашиглан шийдэж болно.

“Green shoe option” гэдэг нь хувьцааны эрэлт төлөвлөж байснаас давж, компанийн хувьцаа санал болгосон үнээс дээгүүр үнээр арилжаалагдахад хөрөнгө оруулагчдад нэмэлт хувьцаа борлуулах эрхийг олгодог гэрээний заалт юм. Иймд, энэхүү эрхийг ашиглан хувьцааны үнийг тогтворжуулах боломжтой байдаг.

“ЭТТ” ХК – ийг салбарын “benchmark” буюу

жишиг компани гэж харж байгаа, учир нь ЭТТ ХК–ийг амжилттайгаар анхдагч зах зээлд арилжиж /IPO хийх/, хувьцааг эргэлтэд оруулснаар бусад уул уурхайн компаниудын хувьд жишиг амжилтыг тогтоож өгч байгаа хэрэг. Нөгөө талаар, “ЭТТ” ХК – ийн IPO–г хийснээр Монголын засгийн газар болоод хөрөнгийн зах зээлд оролцогчдын хувьд маш үнэ цэнэтэй туршлага болох юм.

Урт хугацаандаа, Монгол Улс уул уурхайн салбарт чиглэсэн, салбарын өсөлтийг дэмжих хөрөнгийг босгох шаардлагатай. Харин тэр мөнгийг хэрхэн татан төвлөрүүлэх вэ гэвэл зөвхөн уул уурхайн салбарыг дэмжих зориулалттайгаар гадны хөрөнгө оруулагчдаас төвлөрүүлсэн санг байгуулах явдал. Үүний тулд засгийн газар холбогдох хуулийг баталж өгөх ёстой байдаг.

Хөрөнгө оруулагчдаас татсан мөнгөөр сан босгон үйл ажиллагаа явуулах тусгай зориулалтын компанийг байгуулснаар зөвхөн “ЭТТ” ХК – ийг бус уул уурхайн салбарыг бүхэлд нь дэмжих боломжтой. Энэхүү арга зам нь мэргэжлийн хөрөнгө оруулагчийг бий болгоод зогсохгүй,

сангийн хөрөнгө оруулалтаар уул уурхайн компаниудын үйл ажиллагааг дэмжих давуу талтай. Үйл ажиллагаа жигдэрсэн компаниуд хувьчлагдах эсхүл IPO хийх замаар зах зээлд гардаг.

Солонгос болон Тайван улсууд аж үйлдвэрлэлийн салбараа дэмжих зорилгоор сангуудыг байгуулж байсан түүхтэй бөгөөд гадны хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгөд хязгаар тавих бодлого баримталж байсан ба улмаар үе шаттайгаар нээлттэй болгосон. Азийн 1997 оны санхүүгийн хямралын үеэр Солонгосын засгийн газар гадны хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэйг ойлгож, гадны хөрөнгө оруулагчдад тавих хязгаарлалтаа бууруулж байсан. Ингэснээр, Солонгосын Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх гадаадын шууд хөрөнгө оруулалт маш огцом өссөн байдаг.

Монгол Улс дээрх улсуудын жишгийг дагаснаар уул уурхайн салбараар дамжуулан, гадны хөрөнгө оруулагчдыг татах замаар урсгал дансны алдагдлаа бууруулах боломжтой.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

НЭГДҮГЭЭР САРД 23 ББСБ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛЛЭЭ.

2019 он гарснаас хойш буюу нэгдүгээр сард 23 ББСБ хувь нийлүүлсэн хөрөнгөө нийт 9,076 сая төгрөгөөр нэмэгдүүлэх хүсэлт ирүүлснийг Санхүүгийн зохицуулах хороо хянан зөвшөөрч, холбогдох бүртгэлд өөрчлөлт орууллаа.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ–ууд хувь нийлүүлсэн хөрөнгийнхөө доод хэмжээг энэ сард 1.4 тэрбум төгрөг хүргэх үе шаттай. Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй чадавхжуулах бодлогын хэрэгжилт сайн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2016 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 724,2 тэрбум төгрөг байсан бол 2018 оны жилийн эцэст 1.3 их наяд төгрөгт хүрч, 66 хувиар

өсөөд байна.

“МОНКОРД” ХЗХ–НД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ТУШААЛ ГАРГАЛАА.

“Монкорд” ХЗХ–нд хийсэн удаа дараагийн газар дээрх хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны дарга тушаал гаргалаа.

Уг тушаалаар “Монкорд” ХЗХ–ны үйл ажиллагаанд үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг судалж шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч, Хорооны дэд дарга Д.Баярсайханд тус хоршоонд хийсэн газар дээрх хяналт шалгалтын явцад илэрч байгаа зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд тус хоршооны үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох зэрэг хуульд заасан холбогдох арга хэмжээ авахыг даалгалаа.

Мөн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж ажиллахыг чиглэл болгов.

Тушаалын дагуу “Монкорд” ХЗХ–ны талаар холбогдох арга хэмжээг дээрх Ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд тус хоршооны гишүүдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, хянан хэлэлцэх, тэдэнтэй уулзаж санал хүсэлтийг сонсох зэргээр шуурхай ажиллах юм.

Түүнчлэн тушаалаар “Монкорд” ХЗХ–ны Тэргүүлэгчдийн зөвлөл болон Хяналтын зөвлөлд Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах, үйл ажиллагааны сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулж ажиллахыг үүрэг болгов. Бүх гишүүдийн хурлыг хуралдуулахдаа хоршооны гишүүдийн ирцийг сайтар хангах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй гишүүдийн оролцоог хангаж, төлөөллийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхийг тусгайлан даалгалаа. Мөн, Бүх гишүүдийн

хуралд хоршооны ардчилсан удирдлага, хамтын хяналттай, ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлсэн байдлын талаар нийт гишүүдэд мэдээлэхийг үүрэг болгосон байна.

ХЗХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙНХӨӨ ХУГАЦААГ ДУУСАХААС 30 ХОНОГИЙН ӨМНӨ ХҮСЭЛТЭЭ ИРҮҮЛНЭ.

Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-ны тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хууль, тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр хүсэлт гаргасан хоршоодод гурван жилийн хугацаагаар олгодог. Үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлтэй ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тавигдах шаардлага болон холбогдох зохицуулалтыг Хороо “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-д нарийвчлан зааж өгсөн.

Тус актаар хоршоод тусгай зөвшөөрлийн хугацаагаа дуусгавар болохоос 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт бүрдүүлэн ирүүлсэн байхаар зохицуулсан байдаг. Мөн нөхцөл, шаардлага хангахгүй байгаа болон хугацаандаа хүсэлтээ ирүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тусгай зөвшөөрлийн хугацаа дууссанаас хойш ирүүлсэн ХЗХ-дын хүсэлтийг Хороо хүлээн авах боломжгүй юм.

ҮЦХОУБ-ААС ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖ ӨГЛӨӨ.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангахад ихээхэн үр дүнтэй, сүүлийн жилүүдэд дэлхий дахинд асар хурдацтайгаар түгэн тархаж буй хамтын санхүүжилт буюу crowdfunding-ийн зохицуулалтын асуудалд санхүүгийн зохицуулагчдын олон улсын байгууллагууд ихээхэн анхаарал хандуулж байна. Тухайлбал, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /ҮЦХОУБ, IOSCO/ хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зөвлөмжийг гишүүн улс орнууд, санхүүгийн зохицуулагч байгууллагуудад өгөөд байна.

Хамтын санхүүжилт буюу crowdfunding-гийн платформууд сүүлийн үед залилан, хууль

бус луйварт өртөх, хөрөнгө оруулалт хүссэн төслүүдийн эзэмшлийн болон зохиогчийн эрх алдагдах, мөн хуурамч компани, платформ үүсгэж хөрөнгө завших тохиолдол багагүй гарч буй аж. Иймд, ҮЦХОУБ-аас санхүүгийн зохицуулагч байгууллагуудад хамтын санхүүжилтийн онлайн платформыг бүртгэж, тэдгээрт олгох тусгай зөвшөөрөлд шаардлага, шалгуурыг сайтар тавьж ажиллахыг зөвлөмж болгосон байна. Ингэхдээ платформуор үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоох, нэг хөрөнгө оруулагчийн тодорхой хугацаанд оруулж болох хөрөнгийн хязгаарыг тогтоох, мэдээллийн ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулагчдыг мэдлэгжүүлэх, хамтын

санхүүжилттэй холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдлийг хөрөнгө оруулагчдаас шаардах, хамтын санхүүжилтээр боссон хөрөнгийг гуравдагч кастодиан банкинд хадгалуулах зэрэг зохицуулалтын олон хэрэгслээс оновчтой хэрэглэх нь зүйтэйг онцлон санал болгож буй юм.

Санхүүгийн зохицуулах хороо Монгол Улсад хамтын санхүүжилтийн эрх зүй, зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр судалж байна. Үүний тулд хамтын санхүүжилтыг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай юм.



САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралдаан өнөөдөр Санхүүгийн зохицуулах хороонд боллоо.

Зөвлөлийн хуралдааныг Хорооны дарга, доктор С.Даваасүрэн удирдан явуулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны 2018 оны тайлан, үр дүн болон ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт авч буй арга хэмжээний талаар хэлэлцлээ. Өнгөрөгч 2018 онд Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж зээлийн хоршооны зах зээлд оролцогчдын зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн салбарт бизнес эрхлэгчдийн эрсдэлийн үнэлгээг анх удаа хийж, энэ чиглэлийн хяналт шалгалтыг улсын хэмжээнд иж бүрэн зохион байгуулсан нь ихээхэн зэрэгээр нөлөөлсөн байна.

СЗХ-НД БҮРТГЭЛТЭЙ ДААТГАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭ

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох, эрх бүхий албан тушаалтныг томилох, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгох, даатгалын бүтээгдэхүүн бүртгэх болон бусад чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2019 оны 2 дугаар сарын байдлаар тус Хороонд даатгалын чиглэлээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг мэдээлж байна.

Өнөөдрийн байдлаар давхар даатгалын хоёр, ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын нэг, даатгалын зуучлагч 49, даатгалын хохирол үнэлэгч 27 компани тус тус Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн 581 даатгалын бүтээгдэхүүн,

564 салбар, 2444 даатгалын төлөөлөгч, 28 актуарч, 281 даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан, 186 даатгалын байгууллагын хувьцаа эзэмшигч Хороонд бүртгэлтэй байна.

11 ХК НИЙТ 54.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ОЛГОНО.

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 46.5-д заасны дагуу Хувьцаат компани (ХК)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэдэг бөгөөд уг шийдвэрээ гурав хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдлээр ирүүлдэг. Хуульд заасан 50 хоног энэ сарын 19-нөөр дуусгавар болсон бөгөөд хуулийн хугацаанд Хороонд нийт 51 ХК мэдэгдлээ ирүүлснээс 11 нь нийт 54.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэжээ.

ХЗХ-Д БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОВОО 3 ДУГААР САРЫН 1-НИЙ ӨДРӨӨС ӨМНӨ ЗАРЛАНА.

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-д ээлжит Бүх гишүүдийн хурал (БГХ)-ын тов, хэлэлцэх асуудлын жагсаалтыг гишүүддээ зарлахад 7 хоног үлдлээ. Энэхүү зарын хугацааг Хадгаламж, зээлийн тухай хуулийн 31.2-т тодорхой заасан бөгөөд хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хүргэхээр тогтоосон.

Хуулиар эрх олгогдсоны дагуу ХЗХ-ны БГХ-ын бэлтгэлийг хангаж, зохион байгуулах ажлыг Тэргүүлэгчдийн зөвлөл (ТЗ) гүйцэтгэх бөгөөд холбогдох бичиг баримт, хэлэлцэх асуудлууд болон бусад бүрдүүлбэрийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлдэг.

ХЗХ-ны ТЗ нь бүх гишүүдийн хурлаас сонгогддог, гурваас доошгүй сондгой тооны гишүүнтэй, хоршооны дээд удирдлагын баг бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн тодорхой эрх, үүрэгтэй. Тухайлбал, ХЗХ-г хөгжүүлэх бодлого, бизнес төлөвлөгөөг боловсруулж, бүх гишүүдийн хурлаар батлуулах, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэх захирлыг томилох, түүнтэй гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чухал үүргүүдийг ТЗ гүйцэтгэнэ. Мөн, ХЗХ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд ТЗ хяналт тавих

бөгөөд хоршооны хадгаламж болон зээлийн журмыг баталж, хүү, төлбөрийг тогтоодог. Цаашлаад, ХЗХ-ны санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандартын дагуу хөтлүүлэн, жилийн санхүүгийн тайланг хяналтын зөвлөл болон бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх, жилийн орлогоос алдагдлыг нөхөх, нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын болон тогтворжилтын сангийн шимтгэлийг бүрдүүлэх, гишүүдэд хүртээх хувь хөрөнгийн хэмжээний талаар санал боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах үүрэгтэй юм.

МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАЖ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД ЭРХ ОЛГОХ СУРГАЛТЫН ТОВЫГ ТОГТООЛОО.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд, энэ салбарт зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэний үндсэн дээр гурван жилийн хугацаагаар олгосон эрхийн хүрээнд ажиллахаар заасан. Уг мэргэшлийн

шалгаруулалтыг Мэргэшлийн зөвлөл эрхлэн гүйцэтгэх бөгөөд есөн гишүүний бүрэлдэхүүнтэй тус зөвлөлийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын томилсон Хорооны гишүүн даргалахаар хуульд тодорхой тусгасан байдаг.

Тус Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг саяхан шинэчлэн томилсон бөгөөд Хорооны орон тооны бус гишүүн Б.Баярдаваагаар даргалуулсан зөвлөл анхдугаар хуралдаанаа хийж, үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах ээлжит сургалтыг зохион байгуулах асуудлыг хэлэлцлээ. Эрх олгох, аттестатчилах сургалтыг тавдугаар сарын 6-17-ны өдрүүдэд явуулахаар товлосон байна.

Мөн хурлаар, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн гаргах хэрэгцээ, шаардлага болон боломжийн талаар хэлэлцэж, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны журам болон Хорооноос батлан мөрдүүлж буй Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмуудад оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар зөвшилцлөө.



ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ 7 БҮСЭД ЯВАГДАВ.

Хөдөө, орон нутагт даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт явагдаж Баруун, Говийн, Хойд, Хангайн, Зүүн бүсийн аймгууд, Төв болон Дорноговь-Говьсүмбэр аймаг гэсэн долоон бүсээр зохион байгуулагдлаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын даатгалын холбоотой мэргэжлийн оролцогчдыг сургах, дахин мэргэшүүлэх талаар хамтран ажиллахаар гэрээ байгуулсан.

Сургалтаар даатгал, төрөл ангилал, тэдгээрийн онцлогийн тухай ерөнхий ойлголт мэдлэгийн зэрэгцээ даатгалын эрсдэл, түүний удирдлагын асуудлууд, Хороонд бүртгэгдсэн даатгалын бүтээгдэхүүнүүд, Монгол Улсын даатгалын хууль, эрх зүйн зохицуулалт, даатгалын төлөөлөгчид

тавигдах шаардлага, гэрээний эрх зүй, бүтэц, гэрээ байгуулах арга зүй, анхаарах зүйлс зэрэг нарийвчилсан асуудлуудаар мэдлэг олгох зорилготой.

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХООР АЖИЛЛАЖ БАЙНА.

Санхүүгийн зохицуулах хороо өнгөрөгч 2018 онд үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын нийт оролцогчдыг хамруулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг анх удаа хийлээ. Үнэлгээний үр дүнд санхүүгийн байгууллагуудын эрсдэл дундаж түвшинд гарсан бөгөөд цаашид тодорхой мөчлөгөөр эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, бодлого

зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай нь тогтоогдсон юм.

Иймд Хороо дээрх үнэлгээнийхээ аргачлалыг боловсронгуй болгох зорилгоор судалгаа хийж, аргачлал боловсруулдаг байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллахаар эрэлхийлж байна.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН УУЛЗАЛТУУД

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг нь санхүүгийн үйлчилгээг хүн амын ядуу буурай давхаргад хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримталдаг байгууллага билээ. Уг нийгэмлэгт дэлхийн өнцөг булан бүрийн хөгжиж буй эдийн засагтай 90 гаруй орон гишүүнчлэлтэй бөгөөд Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь тус нийгэмлэгийн гишүүн билээ. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг нь нийт 6 ажлын хэсэгтэй бөгөөд 2019 оны 03 дугаар сарын 11–нээс 15–ны өдрүүдэд “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл (FID)” ажлын хэсгийн 19 дахь, “Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх (GSP)” ажлын хэсгийн 10 дахь удаагийн уулзалтуудыг Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Каир хотод, мөн 2019 оны 03 дугаар сарын 25–наас 29–ний өдрүүдэд “Цахим санхүүгийн үйлчилгээ (DFS)” ажлын хэсгийн 19 дахь, “Хэрэглэгчийг чадавхжуулах, зах зээлийг зохицуулах (CEMC)” ажлын хэсгийн 17 дахь удаагийн уулзалтыг Багамын Хамтын Нөхөрлөлийн Улсад тус тус зохион байгуулах юм. Ингэхдээ ажлын хэсгүүд хамтарсан болон тус бүрийн уулзалтуудыг хийдэг.

Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Каир хотод зохион байгуулах уулзалтаар Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай арга хэрэгсэл, бодлогын шийдвэр, бусад улс орнуудын туршлагатай санал солилцож, цахим санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байгаа нөхцөлд үүсэх санхүүгийн салбарын цахим аюулгүй байдал буюу шинэ төрлийн эрсдэлийг зохицуулах шаардлага, Регтекийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд, хүндрэл бэрхшээл зэргийг судалж, ажлын хэсэг тус бүр чиг үүргийн дагуу хийгдсэн ажлууд болон цаашид хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган хэлэлцүүлнэ.

Мөн санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлийн ажлын хэсгийн хүрээнд санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлийн бодлогын загварын зорилго, хамрах хүрээ болон дараагийн уулзалтад танилцуулах төслийг бэлтгэхэд шаардлагатай арга хэмжээ, хүйсийн тэгш байдлыг тодорхойлох өгөгдлийн сангийн хүрээг хөгжүүлэхэд ашигласан аргачлал, сургамжийн талаар гишүүн улсуудын туршлага судлах зэрэг асуудлуудыг ярилцана. Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх ажлын хэсгийн хүрээнд олон улсын стандарт тогтоох байгууллагуудын боловсруулсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн хүртээмжийг харгалзан зохистой бодлого боловсруулсан гишүүн улсуудын туршлагыг судлах, санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр (FSAP)–ийг хэрэгжүүлэхэд санхүүгийн хүртээмжийг хэмжих аргачлалуудыг хамруулах талаар суралцах, харилцагчийг таньж мэдэх дижитал платформуудтай

танилцаж, уг шинэлэг аргачлалуудыг хэрхэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартын дагуу хэрэгжүүлэх зэрэг асуудлуудаар санал солилцоно.

Багамын Хамтын Нөхөрлөлийн Улсад зохион байгуулагдах уулзалт нь гишүүн орнууд цахим санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр тулгамдсан асуудал, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зэрэг асуудлаар хэлэлцүүлэг хийж, харилцан туршлага солилцох боломжтой платформыг бий болгож өгөх явдал юм. Цахим санхүүгийн үйлчилгээ нь дараах дэд ажлын хэсгүүдтэй. Үүнд:

- Хил давсан инновацийг дэмжсэн шилжүүлэг,
- Цахим санхүүгийн үйлчилгээний индикаторууд,
- Финтек болон санхүүгийн хүртээмж,
- Харилцагчийг таних механизмыг инновацууд,
- Систем хоорондын хөрвөх чадвар,
- Цахим санхүүгийн аюулгүй байдал.

Энэ удаагийн DFS ажлын хэсгийн уулзалтаар цахим санхүүгийн аюулгүй байдал, жөндөр болон цахим санхүүгийн үйлчилгээ, цахим санхүүгийн үйлчилгээний индикаторуудын талаар холбогдох дэд ажлын хэсгийн хэсгүүд танилцуулга хийхээр төлөвлөсөн. Түүнээс гадна Бутан улсын Үндэсний төлбөрийн системийн зөвлөл байгуулагдаж байгаатай холбоотой ажлын хэсгүүд санал, дүгнэлтээ өгнө. Энэ удаагийн уулзалтаар санхүүгийн хүртээмж болон уур амьсгалын өөрчлөлтийн тухай хэлэлцэхээр болсон нь өмнөх уулзалтуудаасаа онцлог болох юм.





ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хамтын санхүүжилт гэдэг нь онлайн платформоор дамжуулан шинэ санаачилга, бүтээгдэхүүн, төсөл, зээлийг санхүүжүүлэх зорилгоор хувь хүн, аж ахуй нэгж байгууллагаас хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагаа юм. Шинээр бизнес эрхлэгчид хөрөнгө татан төвлөрүүлэхийн тулд банк болон томоохон санхүүгийн институт, эхлэлийн үйл ажиллагааг дэмжих сангаас (venture capital fund) дэмжлэг авдаг байсан бол хамтын санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглан сая сая хөрөнгө оруулагчид, хандивлагчдаас онлайн платформоор дамжуулан хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой болсон байна.

Зураг 1. Хамтын санхүүжилтийн тогтолцоо



Хамтын санхүүжилтийг дэмжих гол зуучлагч нь онлайн платформ бөгөөд энэхүү платформоор дамжуулан эх үүсвэр шаардлагатай этгээд нь ямар зүйлд хэдий хэмжээний хөрөнгө шаардлагатай, мөн хөрөнгө оруулснаараа ямар өгөөж эргэн хүртэх зэргийг харуулсан саналыг тавьдаг. Хөрөнгө оруулах сонирхолтой этгээд энэхүү саналыг нь харгалзан үзсэнээр санхүүжүүлэх

эсэхээ шийднэ. Ихэнх платформууд all-or-nothing загварыг ашигладаг ба зорилтот мөнгөн дүн тогтоосон цаг хугацаанд бүрдээгүй бол санхүүжилтийг нь зогсоож, бүрдсэн хөрөнгийг эздэд нь буцааж олгодог зарчимтай.


Хамтын санхүүжилт нь дараах үндсэн 4 төрөлтэй :

1. Урамшуулалд (reward-based) суурилсан – Ямарваа нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ирээдүйд худалдахаар хөрөнгө татан төвлөрүүлэх;
2. Хандивт (donation-based) суурилсан – Сайн үйлсэд зориулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх /Wikipedia, Red cross/;

3. Зээлд (debt-based or peer-to-peer lending) суурилсан – Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг бусдад зээлдүүлэх;

4. Үнэт цаасанд (equity-based) суурилсан – Хувьцаа гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх;

Урамшуулалд болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь олон нийтийн хамтын санхүүжилт, өр зээлд болон үнэт цаасанд суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь санхүүгийн өгөөж хүртэх хамтын санхүүжилт гэж нэрлэдэг . Эдгээр төрлүүдийн гол ялгаа нь эхний хоёр төрөл нь ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт эсвэл санхүүгийн өгөөж хуваарилдаггүйд оршино.



ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ДАВУУ ТАЛ БОЛОН СУЛ ТАЛУУД

Давуу тал: Хамтын санхүүжилтийн хамгийн том давуу тал нь хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар, бага зардалтайгаар татан төвлөрүүлэх, зах зээлд суурилсан санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж юм. Тиймээс ч улс орнууд энэхүү салбарыг эрх зүйн зохицуулалтаар дамжуулан дэмжих сонирхолтой байдаг. Хамтын санхүүжилт нь дараах давуу талуудтай:

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг хямд зардлаар бий болгон, бодит эдийн засгийн хөгжлийг хангах – Эдийн засагт жижиг дунд бизнес томоохон үүрэг гүйцэтгэдэг учраас эдгээр бизнес шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх механизм нь ажил эрхлэлтийг

нэмэгдүүлж, цаашдаа эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой.

- Банкны орхигдуулсан орон зайг нөхөх – 2008 оноос хойш банкуудад тавигдах хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт өндөрссөн бөгөөд үүний үр дүнд иргэд, жижиг, дунд бизнест олгох зээлийн хэмжээ эрс буурсан. Хамтын санхүүжилт нь банкны үйлчилгээг авч чадахгүй байгаа энэхүү орон зайг нөхөх ач холбогдолтой.
- Хөрөнгө оруулалтын зардал бага – Онлайн платформ нь банкуудыг бодвол нүсэр бүтэцгүй, удирдлагын зардал багатай тул хөрөнгө оруулалтын зардлыг бууруулна.

Эрсдэл: Хамтын санхүүжилт нь нэг талаар иргэдэд шинэ, ирээдүйтэй бизнест хөрөнгө оруулах, нөгөө талаар бизнест эрхлэгчдэд хөрөнгө татан төвлөрүүлэх



боломжийг бүрдүүлснээр аливаа улс орны хувьд эдийн засгийн гол хөдөлгүүр болсон жижиг дунд үйлдвэрлэлийг санхүүжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах давуу талуудтай боловч эрсдэлийг дагуулдаг үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагаа нь дараах эрсдэлүүдтэй:

- Залилангийн эрсдэл /Risk of fraud/ – Хуурамч компани байгуулан хөрөнгө татан төвлөрүүлэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, хүний санааг зөвшөөрөлгүйгээр хэрэглэх зэргээр залилангийн үйл ажиллагаа явуулах боломжтой. Жишээлбэл, АНУ-д Kickstarter.com вебсайтаар дамжуулан The Doom That Came to Atlantic City гэх нэртэй ширээний тоглоом зохион бүтээхээр төслийн санаачлагч нь хөрөнгө босгосон бөгөөд анхны санал болгосон 35,000 ам.доллараас хамаагүй илүү буюу 123,000 ам.долларыг 1200 хүнээс цуглуулжээ. Тухайн тоглоомыг бүтээх, үйлдвэрлэх, хэрэгчлэгчдэд хүргэхэд зарцуулагдах ёстой мөнгийг төслийн санаачлагч нь өөр зориулалтаар буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан нь дараа тогтоогдсон байна. Эцэстээ тэрээр энэхүү төслөө хаасан боловч хөрөнгө оруулагчдад мөнгийг буцаан олгоогүй бөгөөд энэхүү хэрэг нь луйврын буюу хууль зөрчсөн явдлын нэг жишээ юм.
- Бизнес дампуурах эрсдэл /Risk of default/ – Жжиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлт, бизнесийн мөчлөг, дидрдлага,

маркетингийн үйл ажиллагаанаас хамааран амжилтгүй болох, дампуурах магадлал өндөр байдаг. Жишээлбэл, хөгжилтэй орнуудад эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн дампуурах магадлал эхний 5 жилд 50% байдаг.

- Хөрөнгө оруулагчдын мэдлэггүй байдлын эрсдэл – Хөрөнгө оруулах шийдвэр гаргах талаар туршлагагүй, мэдлэггүй хөрөнгө оруулагчид оролцдог тул хууран мэхлэгчид болон бусад хүмүүс тэдгээрийг өөрт давуу байдлаар ашиглах боломж их байдаг.
- Хөрвөх чадварын эрсдэл – Үнэт цаасанд суурилсан хамтын санхүүжилтийн хувьд хөрөнгө оруулагч хоёрдогч зах зээл дээр арилжих боломжгүй байдаг.
- Кибер халдлагын эрсдэл – Онлайн платформаар дамжуулан явагддаг учир кибер халдлагад өртөх магадлалтай.
- Мөнгө угаах эрсдэл – Мөнгө угаах үйл ажиллагаанд далдуур ашиглах, хууль бус мөнгөний гарал үүслийг өөрчлөн хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэх боломжтой.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангахад ихээхэн үр дүнтэй, сүүлийн жилүүдэд дэлхий дахинд асар хурдацтайгаар түгэн тархаж буй хамтын санхүүжилт буюу crowdfunding-ийн зохицуулалтын асуудалд санхүүгийн зохицуулагчдын олон улсын байгууллагууд ихээхэн анхаарал хандуулж байна. Тухайлбал, Үнэт цаасны хороодын

олон улсын байгууллага /ҮЦХОУБ, IOSCO/ хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зөвлөмжийг гишүүн улс орнууд, санхүүгийн зохицуулагч байгууллагуудад өгөөд байна.

Хамтын санхүүжилт буюу crowdfunding-гийн платформууд сүүлийн үед залилан, хууль бус луйварт өртөх, хөрөнгө оруулалт хүссэн төслүүдийн эзэмшлийн болон зохиогчийн эрх алдагдах, мөн хуурамч компани, платформ үүсгэж хөрөнгө завших тохиолдол багагүй гарч буй аж. Иймд, ҮЦХОУБ-аас санхүүгийн зохицуулагч байгууллагуудад хамтын санхүүжилтийн онлайн платформыг бүртгэж, тэдгээрт олгох тусгай зөвшөөрөлд шаардлага, шалгуурыг сайтар тавьж ажиллахыг зөвлөмж болгосон байна. Ингэхдээ платформуор үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоох, нэг хөрөнгө оруулагчийн тодорхой хугацаанд оруулж болох хөрөнгийн хязгаарыг тогтоох, мэдээллийн ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулагчдыг мэдлэгжүүлэх, хамтын санхүүжилттэй холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдлийг хөрөнгө оруулагчдаас шаардах, хамтын санхүүжилтээр боссон хөрөнгийг гуравдагч кастодиан банканд хадгалуулах зэрэг зохицуулалтын олон хэрэгслээс оновчтой хэрэглэх нь зүйтэйг онцлон санал болгож буй юм.

Санхүүгийн зохицуулах хороо Монгол Улсад хамтын санхүүжилтийн эрх зүй, зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр судалж байна. Үүний тулд хамтын санхүүжилтийг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай юм.

ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд технологийн дэвшил хурдацтай нэвтэрч санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанаас эхлэн хэрэглэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх хандлагад нөлөөлөх, цаашлаад эдийн засгийн хөгжил, тэгш бус байдал, ядуурлын асуудлуудыг шийдвэрлэхэд тус болохуйц томоохон өөрчлөлтийг авчирч, салбарыг бүхэлд нь өөрчилж байна.

Санхүүгийн салбарт гарч буй энэхүү инновацийг бид “Финтек” гэж нэрийдэж байна. Финтек нь санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхээс гадна төлбөр тооцооны үйлчилгээ, хөрөнгө оруулалт, менежментийн үйл ажиллагаа, даатгал, зээлийн бүтээгдэхүүн зэрэг санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд нэвтэрч байна. Үүнээс хамгийн амжилттай нэвтэрч эдийн засаг, иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц эерэг нөлөөг үзүүлж байгаа нэг төрлийн бүтээгдэхүүн бол технологид суурилсан зээлийн үйлчилгээ юм. Технологийн дэвшлийг зээлийн үйл ажиллагаанд ашигласнаар санхүүгийн байгууллагуудын зардал буурах, санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжрах, уламжлалт банкны зээлийн үйлчилгээнээс хасагдсан иргэд, аж ахуй нэгжүүдэд санхүүжилтийн олон төрлийн боломж нээгдэх зэрэг олон давуу тал үүсэж байна.

Статистик дүнгээс харахад технологид суурилсан зээлийн үйлчилгээ хамгийн өргөн хүрээнд нэвтэрсэн улс нь Хятад, үүний дараагаар АНУ, Их Британи зэрэг улсууд байна. Эдгээр улсуудын хувьд нэг хүнд ногдох финтек зээлийн дүн нь 60–110 ам.доллар байна. Мөн АНУ, Герман, Солонгос, Шинэ Зеланд зэрэг улсуудын хувьд технологид суурилсан зээлийн үйлчилгээний дийлэнх буюу 80 гаруй хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байгаа бол Австрали, Япон, Нидерланд улсуудын хувьд аж ахуй нэгжүүд нь технологид суурилсан зээлийн үйлчилгээг бусад улс орнуудаас илүү их ашиглаж байна.

Дараах төрлийн финтек зээлийн загварууд санхүүгийн зах зээлд түгээмэл ашиглагдаж байна. Үүнд:


Уламжлалт P2P зээлийн загвар: P2P зээлийн загвар нь зээл олгогч, зээл хүсэгч, тэднийг холбох үүрэг бүхий платформуос бүрдэнэ. Зээл хүсэгч иргэн нь платформд өөрийн мэдээллээ оруулж, бүртгүүлснээр платформын үйл ажиллагаа эхэлдэг. Платформ нь зээлдэгчийн мэдээллийг шинжлэн баталгаажуулах бөгөөд зээл олгогч буюу хөрөнгө оруулагч нар зээлийн хэмжээ, хугацаа, зориулалт болон зээл хүсэгчийн орлого зэрэг мэдээлэлд суурилан санхүүжүүлэх зээлээ сонгоно. Дундын платформ нь зээлдэгчийн эрсдэлийг үнэлэх, зээлдэгчтэй холбоотой тоон мэдээллийн санг үүсгэх зэрэг үүргийг гүйцэтгэн ажилладаг.

Энэтхэг, Хятад улсуудад ашиглагдаж буй P2P зээлийн платформууд нь арилжааны банкны тоон мэдээллийн сангаас илүү том, илүү нарийвчлал сайтай тоон мэдээллийн сан үүсгэж, олон төрлийн шинжилгээг хийх бүрэн чадвартай болж хөгжсөн байна.

Одоогоор үйл ажиллагаа явуулж буй ихэнх P2P платформууд нь хөрөнгө оруулагчдыг хэд хэдэн зээлийн төслүүдийг давхар сонгож, эрсдэлээ тархаахыг санал болгодог бөгөөд хөрөнгө оруулагчийн хүссэн шаардлагын дагуу автоматаар хөрөнгийг нь олон төрлийн зээлийн төслүүдрүү хуваарилдаг үйлчилгээ мөн ашиглагдаж байна. Тухайлбал 2016 онд CCAF-с хийгдсэн нэгэн судалгааны үр дүнгээс харахад Европын P2P платформуор хийгдэж буй иргэдийн зээлийн 80 хувь, бизнесийн зээлийн 40 хувь нь уг автоматаар сонгох механизмыг ашиглаж байна.

Мөн Австрали, Хятад, Итали, Өмнөд Африк, Их Британи зэрэг улсуудад үйл ажиллагаа явуулж буй P2P платформууд нь хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө буцаан авахыг хүссэн тохиолдолд тодорхой хэмжээний шимтгэл аван зээлийн дүнг өөр хөрөнгө оруулагчид шилжүүлдэг үйлчилгээг санал болгож байна.

Зураг 2. Уламжлалт P2P зээлийн загвар



Нотари зээлийн загвар: Нотари зээлийн загвар нь мөн хөрөнгө оруулагч, зээлийн төслийг холбох үүрэг бүхий платформын хүрээнд ажилладаг хэдий ч зээлийг дундын банк нийлүүлдэг онцлогтой. Энэ төрлийн финтек зээлийн платформууд нь Герман, Солонгос, АНУ-д өргөн ашиглагдаж байна.

Зээл хүсэгч, хөрөнгө оруулагчийг холбосон мэргэжлийн санхүүгийн байгууллага зээлийн платформтой хамтран ажиллах нь илүү эрсдэл багатайд тооцогдож байгаа тул энэ төрлийн загвар илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ БОЛОВСРУУЛАХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

1. Оршил

Үндэсний санхүүгийн хүртээмжийн стратеги (ҮСХС) – ийн үндсэн агуулгыг боловсруулахаас өмнө “Энэхүү стратегийг боловсруулах нь яагад чухал вэ?” гэх уншигчийн асуултад хариулах үндэслэл, шаардлагатай байх нь чухал. Энэ асуултад хариулснаар яагад санхүүгийн хүртээмжийг бодлогын зорилт гэж чухалчлан авч үзэх үндэслэлийг тодорхойлдог. Ийм ч учраас ҮСХС нь ихэнхдээ дараах хоёр зүйлийг багтаасан өмнөх үг эсхүл танилцуулгаас эхэлдэг байна:

1. ҮСХС-ийн хамрах хүрээ нь улс орны эрх бүхий байгууллагууд болон бусад оролцогч талуудын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой өгсөн амлалт, үндсэн чиглэлүүдтэй хэрхэн хамаарч байгаа байдал
2. ҮСХС нь улс орны санхүүгийн салбар, үндэсний төлбөрийн системийн хөгжил, эдийн засгийн хөгжил дэвшил, ядуурлыг бууруулах зорилт болон одоогийн санаачилж буй ажлуудтай хэрхэн уялдаж болон дэмжиж байгаа талаар. ҮСХС нь бусад холбогдох стратеги болон хөтөлбөртэй хэрхэн уялдаж хэрэгжих талаархыг тодруулах нь зүйтэй.

1.1. ҮСХС-ийн алсын хараа

ҮСХС-ийн үндсэн чиглэл болох алсын хараа болон гүйцэтгэлийн хугацаа нь дэд бүлэг

хэлбэрээр эсхүл дээр дурдагдсан оршил хэсгийн нэгэн хэсэг болон орж болдог.

Жишээ: Танзани улсын ҮСХС нь алсын хараагаа дараах байдлаар тодорхойлов: Танзани улсын бүх иргэд шокыг бууруулах болон мөнгөн гүйлгээг удирдах үүднээс санхүүгийн үйлчилгээ болон төлбөрийн дэд бүтцийг тогтмол ашигладаг. Эдгээрийг албан ёсны үйлчилгээ үзүүлэгчид зохих үйлчилгээ болон дэд бүтцээр дамжуулан нэр төртэй шударга байдлаар хүргэнэ.

1.2. Санхүүгийн хүртээмжийн тодорхойлолт

Тухайн улсын нөхцөл байдалд үндэслэн Санхүүгийн хүртээмжийн тодорхойлолт дэд бүлэг хэлбэрээр эсхүл дээр дурдагдсан оршил хэсгийн нэгэн хэсэг болон орж болдог.

Жишээ: Чанартай, цаг үеэ олсон, тохиромжтой санхүүгийн үйлчилгээ болон бүтээгдэхүүнийг хямд үнээр авах. Хүн амын бүх давхаргын иргэдийн оновчтой шийдвэр гаргалт болон санхүүгийн чадавхийг сайжруулах үүднээс тэдгээр үйлчилгээ нь санхүүгийн боловсролыг дэмжих мөн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий зохицуулалтан дор байдаг. (Парагуай, ҮСХС)

Санхүүгийн хүртээмж гэдэг нь насанд хүрсэн иргэд тэдгээрийн хэрэгцээг хангах төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээг хялбар болон хямд үнээр хүртэхийг хэлнэ. (Нигер, ҮСХС)

2. Өнөөгийн байдлын үнэлгээ

Үнэлгээний хэсэг нь ҮСХС-ийн аналитик суурь нь болж өгдөг бөгөөд өмнөх бүлэгт тодорхойлсон алсын хараанд хүрэхэд тулгарах саад бэрхшээл болон боломжуудыг тодорхойлох зорилготой. Тэдгээр бэрхшээл болон боломжуудыг тодорхойлох нь ҮСХС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго болон зорилт зэргийг боловсруулах үйл явцыг мэдээллээр хангах чухал үүрэгтэй.

Жишээ: Парагуай-ийн ҮСХС-ийг боловсруулах үйл явцыг мэдээллээр хангах үүднээс эрх баригчид Дэлхийн банктэй хамтран 4 төрлийн баримтыг боловсруулсан: (i) иргэдийн эрэлт талын үндэсний хэмжээний судалгаа; (ii) одоогийн санхүүгийн бүтээгдэхүүн болон үйлчилгээний нийлүүлэлт талын үндэсний хэмжээний судалгаа; (iii) санхүүгийн хүртээмжийг дэмжих хууль эрх зүйн зохицуулалт; (iv) хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалал болон санхүүгийн боловсролын үнэлгээ.

3. Стратегийн зорилт

ҮСХС-ийн 1 дүгээр бүлэг буюу алсын хараа мөн 2 дугаар бүлэг буюу саад бэрхшээлд үндэслэн зорилтууд нь тодорхойлогддог. Тэдгээр зорилтууд нь бодлогын тэргүүлэх чиглэл, зорилтот хүн амын бүлэг, интервенцийн төрлүүд эсхүл эдгээрийг хослуулсан хэлбэрээр илэрхийлэгддэг.



3.1. Тэргүүлэх бодлогын чиглэл

Бодлогын чиглэлүүд нь ҮСХС–ийн алсын хараанд хүрэх ач холбогдлынхоо дагуу эрэмбэлэгддэг бөгөөд дангаар бүлэг эсхүл ҮСХС–ийн зорилтуудын нэгэн хэсэг болон орж болдог.

Бодлогын чиглэлүүд нь тухайн улс орны онцлог шинж чанар, нөхцөл байдалд үндэслэн янз бүр байж болдог. Жишээ нь: санхүүгийн чадавх, санхүүгийн дэд бүтэц, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, бичил жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилт зэрэг.

3.2. Зорилтот бүлэг

ҮСХС нь тодорхой зорилтот бүлгийг чиглэн боловсруулагддаг бөгөөд тэдгээр зорилтот бүлгүүд нь хэд хэдэн хүчин зүйлээр тодорхойлогдож болно. Жишээ нь:

- Хүн ам зүйн үзүүлэлт (Эмэгтэйчүүд, залуучууд)

- Орлогын түвшин
- Газар зүйн байршил (Хөдөө орон нутаг, хот суурин)
- Эдийн засгийн үйл ажиллагаа (Хөдөө аж ахуйгаас хамааралтай айл өрх)

3.3. Стратегийн тулгуур/бүрэлдэхүүн хэсэг

Зарим тохиолдолд ҮСХС–ийн зорилтууд нь тус стратегийг бүрдүүлэх тулгуур буюу бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваагдан бүтэц хэлбэрээр зохион байгуулагддаг. Энэхүү бүтэц нь ҮСХС–ийн алсын хараанд хүрэх тулгуур нөхцөл болон арга замуудыг тодорхойлж өгдөг байна.

Жишээ: Филиппин улсын ҮСХС–ийн бүтэц нь алсын хараанд хүрэх 4 тулгуур хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг бөгөөд байшин хэлбэрээр дүрсэлсэн байдаг. Байшингийн дээвэр хэсэгт алсын харааг тодотгож өгөн тулгуур хэсэгт түүнд хүрэх 4 чиглэлийг тодорхойлж өгсөн.

системтэй /Monitoring and Evaluation system/ (M&E) байхыг шаарддаг.

Эдгээр нөхцөлүүд хангагдсаны үндсэн дээр M&E систем нь саад тотгорыг илрүүлэх, үр дүнг илэрхийлэх болон нөөцийг үр ашигтайгаар хуваарилах үр дүнтэй, мөн чадалтай хэрэгсэл болж чадах юм.

M&E–н системийн 4 гол хэсэг:

1. Нийлүүлэлт болон эрэлт талын зохистой болоод үнэн зөв өгөгдөл нь санхүүгийн үйлчилгээний чанар, хэрэглээ болон ашиглалтын талаарх цогц ойлголтыг өгнө.
2. M&E–н үр дүнгийн тогтолцоо (results framework) нь үндэсний тэргүүлэх чиглэлтэй уялдсан зорилтууд болон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тогтоодог.
3. Гол шинэчлэл болон хөтөлбөрүүдийг үнэлэх нь тэдгээр үйл ажиллагаануудын нөлөө, үр ашгийн талаарх ойлголтыг өгнө.
4. ҮСХС–ийн M&E–н хэсэг нь тус системийн хэрэгжилт болон координацын механизмыг тодорхойлох шаардлагатай бөгөөд ажлын хэсэг эсхүл тусгай мэргэжлийн багийг дайчилж болно.

6. Үйл ажиллагааны төлөвлөгөө

Үндэсний санхүүгийн хүртээмжийн стратегийн энэхүү бүлэг нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт, шинэчлэлт зэргийг багтаана. Үүнд:

- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлбар
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгж байгууллага (Олон байгууллага хэрэгжүүлж байгаа тохиолдолд гол хэрэгжүүлэгч байгууллагыг зааж өгөх)
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрэмбэ (өндөр, дунд, бага)
- Зарим үйл ажиллагаа түргэн хугацаанд гүйцэтгэгддэг эсэх
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хангагдах шаардлагатай урьдчилсан нөхцөлүүд

Эх сурвалж: Дэлхийн банк “Үндэсний санхүүгийн хүртээмжийн стратегийг боловсруулах загвар”



4. Координац, хэрэгжилтийн механизм

ҮСХС–ийн координац, хэрэгжилт нь ҮСХС–ийг боловсруулах үйл явц дээр үндэслэдэг. Тус стратегийг боловсруулж эхэлхээс оролцоотой бүхий л талууд хоорондоо зөвлөлдөх замаар ҮСХС–ийг боловсруулдаг. Тэдгээр оролцогч талуудыг координац хийх төрөл бүрийн механизмууд байдаг. Хэлэлцүүлэг семинар, тогтмол уулзалтууд зэргийг зохион байгуулан ҮСХС–ийн хэрэгжилтийн талаар мэдээллээ солилцдог байна.

4.1. Оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага

ҮСХС–ийг хэрэгжүүлэх оролцоо бүхий талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаарх хэсэг нь дэд бүлэг хэлбэрээр эсхүл

координац, хэрэгжилтийн механизм бүлгийн нэгэн хэсэг болон орж болдог.

Жишээ: Энэтхэг улсын ҮСХС–д стратегийн зорилгод хүрэхийн тулд оролцогч талуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Оролцогч талууд дараах төлөөллүүдээс бүрдэх бөгөөд, үүнд: Сангийн яам, Энэтхэгийн Төв банк, банкууд, бусад Засгийн газрын байгууллагууд зэрэг юм.

5. Хяналт, үнэлгээний систем

Үндэсний санхүүгийн хүртээмжийн стратегид (ҮСХС) тусгагдсан санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилтуудын биелэлтийг хэмжихэд бүх төрлийн оролцогч талуудын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нөөцөөр бүрэн хангагдсан, сайн зохицуулагдсан Хяналт, шинжилгээний

ОЛОН УЛСЫН ШИНЖЭЭЧДИЙН ДҮГНЭЛТ



2018 он даатгалын зах зээл болон даатгалын технологийн салбарт томоохон өөрчлөлтүүд бий болсон жил байлаа. 2019 онд даатгалын зах зээл болон тус зах зээлд хөгжиж буй шинэ технологийн талаар даатгалын зах зээлийн мэргэжлийн шинжээчдийн хүлээлтийг танилцуулж байна.

“Northwestern Mutual”-ийн түнш Craig Schedler

2019 он даатгалын технологийн хувьд чухал жил байх болно. Сүүлийн жилүүдэд даатгалын салбар дахь их хэмжээний хөрөнгө болон хүүгийн орлого нь гарааны бизнес эрхлэгчдийн сонирхлыг их татаж байна. Даатгалын технологийн компаниуд даатгалын салбарт өөрчлөлт авч ирэх шинэ бүтээгдэхүүнээ танилцуулж эхлэх цаг үе ирж байна.

“Делоитт”-ийн даатгалын судалгааны удирдах албан тушаалтан: Sam Freedman

Делоитт төвийн 10 дугаар сарын эхний 2 долоо хоногийн мэдээллээс үзэхэд insurtech нь чухал хугарлын цэгтээ хүрсэн байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд шинэ гарааны бизнесүүдийн тоо эрс буурч байсан ч insurtech-ийн санхүүжилт амжилттай хэвээр байгаа бөгөөд даатгагч болон бусад гадны хөрөнгө оруулагчид нь илүү өндөр түвшний, бодит боломж, хүрч болох үр дүн бүхий хөгжиж буй шийдлүүдэд илүү анхаарлаа хандуулж байна.

“ProSight Specialty Insurance” компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал: Joe Beneducci

Уламжлалт даатгал болон insurtech аль аль нь хүчирхэг ч гэсэн харилцагчдын эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр тэдний хүчин

чадлын хүрэлцээгүй байдал нь 2019 онд илүү тодорхой харагдах болно. Жишээлбэл: даатгалын компаниудын даатгалын гэрээний борлуулалтын үйл явц нь тийм ч үр дүнтэй, хялбар биш байгаа нь үйлчлүүлэгчдийг залхааж байгааг 2019 онд тодорхой харж болно.

Даатгал нь даатгуулагчид илүү тохиромжтой, хэрэгцээтэй болж байна.

Маш өргөн хүрээний зохицуулалттай салбар бүхий даатгалын зах зээл нь шинэ технологийг нэвтрүүлж хэрэглэхэд удаан байсан юм. Энэхүү өөрчлөлт нь бизнесийн үйлчлүүлэгчидтэй харилцах хэсгээс эхэлж байна. Хэрэглэгчид тохирсон тусгай технологи нь томоохон хэмжээний мэдээлэл болон хиймэл оюун ухааны тусламжтайгаар тус салбарыг илүү аятайхан, нөхөрсөг болгож эхэлж байна.

“Haven Life” компанийн захирал: Yaron Ben-Zvi

Ач холбогдол өндөртэй гэрээ: Өмнө нь даатгалын салбар болон харилцагч хоорондын харилцаа нь сар бүрийн төлбөр эсвэл нэхэмжлэлээр хязгаарлагддаг байсан. Ерөнхийдөө даатгагчид харилцагчидтай илүү утга учиртай харилцаа холбоо тогтоох хэрэгтэй гэдгийг ойлгож эхэлж байна. Миний харж байгаагаар ирэх жилд даатгалын компани болон төлөөлөгчид даатгалын гэрээ эзэмшигчдээ илүү сайн таньж мэдсэнээр илүү үр өгөөжтэй ажиллах болно.

Хэрэглэгчиддээ тохиромжтой үнэ санал болгох: Даатгалын салбарт шинээр оролцогчид том өгөгдөл суурилсан хамгийн сүүлийн үеийн технологи нэвтрүүлснээр илүү тохиромжтой үнэ тогтоож байна. Үүний үр

дүнд даатгагчид андеррайтинг хийхдээ илүү нарийн боловсронгуй болж байгаа бөгөөд хувь хүмүүсийн эрсдэлийг илүү бодитой үнэлэх боломжийг олгож байна.

Хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн автоматжуулалт: Хэрэглэгчдийн туршлага болон өртгийн сүлжээнд энэхүү автоматжуулалтыг харж болно. Chatbots программ шиг энгийн хүсэлт, андеррайтингийн хүсэлт гаргах, хувийн мэдээллийн нэгдлийн задаргаа харах зэрэг дээр энэхүү автоматжуулалтыг ашиглаж болно. Автоматжуулалт нь салбарыг илүү хурдтай, илүү ухаалаг болгохын зэрэгцээ хаана хүний хүчин зүйл илүү хэрэгтэй байгааг тодорхойлж байна.

“Boost Insurance” компанийн гүйцэтгэх захирал: Alex Maffeo

Даатгалын салбарт бизнес эрхлэгчдэд тулгардаг гурван асуудал байдаг:

1. Шинэ бараа бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахад удаан
2. Өндөр хөгжсөн технологи бүхий гарааны бизнес болон доогуур хөгжилтэй технологи бүхий даатгалын компаниудын хоорондох нэгдэл, мэдээллийн урсгалын асуудлууд
3. Хариуцагч албан тушаалтан болон гарааны бизнес эрхлэгчид хоорондын соёлын уялдаа холбоогүй байдал

Тус салбарын томоохон чиг хандлагын нэг нь үйл ажиллагаагаа тогтмол байлгаж, үүнд оролцдог компаниуд (Oscar, Hippo, Lemonade гэх мэт) амжилт гаргах явдал юм. Өнөөдрийн үйлчлүүлэгч нь өөрийн даатгалын компаниаг шууд харилцахаа багасгаж, нэг цэгийн үйлчилгээний шийдэлтэй байхыг хүсч байна. (Тухайлбал: түрээслэгч нь шууд Airbnb дэх захиалгын төвд хандах)

Insurtech, Big Data болон хиймэл оюун ухаан том асуудлуудыг шийддэг.

Хэрэв та технологиор солигдсон бусад салбаруудыг харвал эхэн үеийн стартапууд хүчтэй өөрчлөлтүүд хийхийн оронд үр ашиггүй байдлыг арилгахад илүү анхаарлаа төвлөрүүлж байна. Insurtech нь томоохон асуудлуудын шийдлийг олохын тулд ажиллаж байгаа бөгөөд харилцагчиддаа үзүүлж буй үйлчилгээгээ илүү сайжруулах нь чухал ч гэсэн одоогийн байдлаар бид муу зүйлс болохоос урьдчилан сэргийлэхийг нэн түрүүнд тавин ажиллаж байгаа компаниудыг харж байна.

ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга



GIZ (**Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit**) буюу Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны салбарт туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг Германы хөгжлийн агентлаг юм. ГОУХАН нь Германы Бонн болон Эшборн хотуудад төвтэй бөгөөд Эдийн засаг хамтын ажиллагааны яамын техникийн хамтын ажиллагааны төслүүдийг голчлон хэрэгжүүлдэг боловч олон нийтийн сайн сайхан байдлын үндсэн дээр бусад дотоодын болон гадаадын байгууллага, засгийн газрын агентлаг, байгууллагуудтай хамтран ажилладаг. Үйл ажиллагаагаа явуулахдаа эдийн засгийн хөгжил, нийгмийн оролцоо болон байгаль орчныг хамгаалах зорилгуудын хүрээнд явуулдаг.

ГОУХАН нь, орон нутгийн хөгжил, тогтвортой дэд бүтэц, нийгмийн хөгжил, засаг захиргаа, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт зэрэг салбаруудад зөвлөх, чадавхыг бэхжүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс

Алсын хараа

Бид дэлхий дахинд үнэ цэнэтэй ирээдүйг бий болгохоор ажилладаг.

Эрхэм зорилго

Бид өөрчлөлтийг удирддаг: Бид хамтран ажиллагсадтайгаа зорилгодоо хүрэхийн тулд туршлага болон хариуцлагаа хуваалцан хамтран нэг бүхэл болон ажилладаг.

Бид ноу-хаугаа хуваалцдаг: Бидний

үйлчилгээ менежментийн мэргэжилтнүүдийн туршин хэрэгжүүлж, хүлээн зөвшөөрөгдсөн техникийн болон бүсийн чадавх дээр суурилсан.

Бид шийдлийг хөгжүүлдэг: Бид өөрсдийн өргөн цар хүрээний сүлжээ болон хэрэгслүүдийг хамтын ажиллагааны үнэ цэнийг бий болгох, хүмүүсийн хөгжих үйл явцыг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахад уян хатан, шинэлэг байдлаар ашиглана.

Бид зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг: Бид төрөл бүрийн сонирхол бүхий этгээдүүдийн хооронд тэнцвэрт байдлыг хадгалж, түүндээ хувийн хэвшил болон иргэний нийгмийн нэвтрэх цэгийг бий болгож өгдөг.

Бид үнэ цэнийг эрхэмлэдэг: Холбооны эзэмшлийн байгууллагын хувьд бид нийгмийн дэг зарчимд захирагдан, Герман улсын ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд, хамгийн түрүүнд Германы засгийн газрын хөгжлийн бодлогыг дэмжиж ажилладаг.

Бид бодлого боловсруулагчдад зөвлөдөг: Бид дотоодын болон гадаадын шийдвэр гаргагчдад улс төрийн зорилгоо биелүүлэхэд тусалдаг.

Бид үр дүнгээ хянадаг: Бидний ажлын үр дүн ил тод, үр ашигтай ба хамтын ажиллагаанд анхаарсан байх бөгөөд бид түүнийгээ арилжааны сайн практикт нийцүүлэн ажилладаг.

Бид дэлхийн тоглогч: Нэг цэгт төвлөрөөгүй бүтэц, соёлын чадавх, мэргэжлийн өндөр ур чадвартай ажилчид нь бидний амжилтын түлхүүр юм.

Байгууллагын үнэ цэнэ

Бид үйл ажиллагаагаа тогтвортой байдлын зарчмын хүрээнд явуулдаг. Бид зөвхөн

нийгмийн хариуцлага, экологийн тэнцвэрт байдал, улс төрийн оролцоо болон эдийн засгийн чадавхын хоорондын уялдааг сайжруулан нэгтгэсэнээр одоо болон ирээдүй хойч үеийнхэнд аюулгүй бөгөөд үнэ цэнэтэй амьдралыг авчирч чадна гэдэгт итгэдэг.

Зорилго болон ашиг сонирхлын зөрчлүүд бүх оролцогчдын дунд шударгаар шийдвэрлэгдэнэ. Хөгжлийг тогтвортой байлгахын тулд ийм төрлийн хэлэлцээрүүд мэргэжлийн түвшинд хийгдэх ёстой. Энэ итгэл үнэмшил нь бидний үйлчлүүлэгчид, хамтран ажиллагчдаар зогсохгүй бие биетэйгээ харилцах харилцаа, үйл ажиллагаагаа хэрхэн явуулахыг чиглүүлдэг.

Бид эдгээр үүргээ биелүүлэхийн зэрэгцээ ХБНГУ-ын Үндсэн хуульд заасан үнэт зүйлсийг дээдлэх үүрэгтэй.

Тодруулбал бид:

- Хүний эрхийг хүндэтгэж, ижил тэгж боломж, шударга байдлыг дээдэлдэг
- Хуулийг дээдлэн, иргэний оролцоог дэмжиж, байгууллагын доторх болон гаднах аль алинд нь шударга хэлэлцээр хийгдэх нөхцөл боломжоор нь хангах үүргийг хүлээдэг
- Зах зээлд төвлөрсөн, экологийн болон нийгмийн эдийн засгийн хэв маягийг дэмжин байгууллагын хариуцлагын зарчмуудыг дагаж мөрддөг.

GIZ ба Монгол Улс

GIZ Монгол Улсад 1991 онд анх үйл ажиллагаагаа явуулж эхлэн, 1998 онд анх өөрийн салбар оффисыг Улаанбаатар хотод байгуулжээ. 2018 оны байдлаар 106 Монгол, 13 гадаад ажилтантай бөгөөд 3 тусгай мэргэжилтэнтэй, 17 хөгжлийн зөвлөх ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.



GIZ нь Монгол Улсад дараах чиглэлүүдийг чухалчлан ажиллаж байна. Үүнд:

- Эрдсийн нөөцийн зохистой буюу тогтвортой хэрэглээ, менежментийн туслалцаа
- Тогтвортой эдийн засгийн өсөлт, хөгжил
- Биологийн төрөл зүйл
- Эрчим хүчний үр ашигтай байдал

Эдгээр нь эдийн засгийн орчныг сайжруулж цаашдаа ядуурлыг бууруулахад шууд бусаар нөлөөлнө гэж үзэж байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хороо ба GIZ

“Системийн эрсдэл, эрсдэлээс хэрхэн гарах” сэдэвт хэлэлцүүлэг



Санхүүгийн зохицуулах хороо нь Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тэй хамтран “Системийн эрсдэл, эрсдэлээс хэрхэн гарах” сэдэвт хэлэлцүүлгийн арга хэмжээг 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Уг арга хэмжээнд Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс олон улсад

танигдсан, нэр хүндтэй эрдэмтэн, судлаач доктор профессор Биатрис Вэдер ди Мауро “Олон улсын санхүүгийн байдал, дэлхийн эдийн засгийн хямралуудаас авах сургамж болон бодлогын арга хэмжээнүүд” сэдвээр, Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрдэмтэн доктор профессор Б.Мөнхзаяа “Монголын санхүүгийн системийн өнөөгийн байдал, учирч болзошгүй эрсдэлүүд” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

Хатагтай доктор профессор Биатрис Вэдер ди Мауро нь Монгол Улсын Засгийн газрын өр их байна, цаашид өрийн удирдлагыг сайжруулах шаардлагатайг онцлон тэмдэглээд, GIZ, “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрийн Захирал доктор профессор Ш.Ханселманн орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийг 30%-иас 10% болгож бууруулсан нь Монгол Улсын эдийн засгийг улам хүнд байдал оруулахыг анхаарууллаа.

Хэлэлцүүлэгт санхүүгийн салбарын оролцогч, зохицуулагч байгууллагуудын нийт 60 орчим төлөөлөгчид оролцсон ба сонирхсон асуултаудаа асууж, мэдээлэл солилцсон.

Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл

GIZ-ийн “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрт дээрх улс орнууд хамрагддаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо 2016 оноос уг хөтөлбөрийн “Бүсийн удирдах зөвлөл”-ийн гишүүнээр ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо олон улсын байгууллагуудтай хамтран даатгалын салбарт төсөл хэрэгжүүлэхээр 2017 онд шалгарсан.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Дэлхийн манлайллын академи /GLA/

болон хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч олон улсын байгууллага /AII/-ууд хамтран хэрэгжүүлдэг “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-дөө хамруулахаар дөрвөн улсыг шалгаруулсны нэг нь Монгол Улс болсон байна.



12 сарын хугацаанд хэрэгжих “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-өөр даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг үнэлж дүгнэлт гарган, цаашид хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх боломжууд, авч хэрэгжүүлэх шинэлэг арга хэрэгслүүдийг судалж тодорхойлох зорилготой. Хороо энэхүү төсөлд оролцож, хамтран ажилласнаар олон улсын туршлагад суурилсан хүртээмжтэй даатгалын шинэлэг зохицуулалтын орчинг нэвтрүүлэх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг бий болгох, даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Төслийн хүрээнд хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг хүртээмжтэй болгох, шинэлэг шийдлүүд дээр суурилсан түгээлтийн сувгийг нээх, нэгдсэн даатгалыг бий болгоход чиглэсэн төрийн зохицуулалтыг сайжруулах зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг авч, шийдвэрүүдийг гарган Монгол Улсын Хүртээмжтэй даатгалын нэгдсэн стратеги төлөвлөгөө баримт бичгийг гаргасан. Төсөлтэй холбоотойгоор 2017 оны 09 дүгээр сард “Хүртээмжтэй даатгалын талаар санал солилцох Олон улсын уулзалт” Монгол Улс анх удаа зохион байгуулсан.



ӨРГӨН ДУРАН

Олон Улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг / CXN, The Alliance for Financial Inclusion, AFI/-ийн бодлого тодорхойлогчдын дээд хэмжээний чуулга уулзалт Бүгд Найрамдах Кот д'Ивуар Улсын Абиджан хотноо 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр эхэллээ. Санхүүгийн зохицуулах хороо 2009 онд тус нийгэмлэгт гишүүнээр элссэн бөгөөд 2016



оноос хойш Хорооны төлөөлөл нийгэмлэгийн бүх зургаан ажлын хэсэгт ажиллаж байгаа юм. Энэ удаагийн чуулганы **“Санхүүгийн хүртээмжийн ирээдүйг шинэчлэх нь”** сэдэвт хуралдааныг Нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн даргаллаа.

Дэлхий дахинд өнөөгийн байдлаар банк, санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 1.7 тэрбум хүн байна гэсэн судалгааг CXN-ээс гаргажээ. Тэдгээр хүмүүст санхүүгийн үйлчилгээг хүргэх стратегийг төлөвлөх, цаашид хүртээмжтэй санхүүг ямар чиг хандлагаар өргөжүүлэн хөгжүүлэхийг тодорхойлох, холбогдох зохицуулалт болон зөвлөмжүүдийг боловсруулах зэрэг өргөн хүрээний асуудлуудыг тус хуралдаанаар хэлэлцэв. Түүнчлэн хөгжиж буй болон хөгжингүй орнуудад тулгарч буй санхүүгийн хүртээмж дэх жендерийн тэгш бус байдлыг багасгах арга зам, тэдгээрийн шийдлүүдийг эрэлхийлж, технологийн дэвшилд суурилан санхүүгийн хүртээмжийг тэлэх боломж, гарцуудын талаар хэлэлцэн, гишүүн улс орнуудын төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагуудад хандан дээрх асуудлуудаар зохих зөвлөмжийг өгөхөөр боллоо.

Бодлого тодорхойлогчдын дээд хэмжээний чуулга уулзалтад CXN-ийн гишүүн төв банкууд, олон улсын байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн дэлхийн санхүүгийн салбарын 180 гаруй удирдагчид оролцож байна. Хорооны дарга, доктор С.Даваасүрэн чуулга уулзалтад тэргүүлэх байр суурьтай оролцож байгаа нь CXN дэх Монгол Улсын оролцоог улам бүр өргөжүүлэх ач холбогдолтой. Учир нь хүн амын эмзэг бүлгийн оролцоо санхүүгийн салбарт нэмэгдэхийн хэрээр улс орны эдийн засгийн өсөлт болон санхүүгийн тогтвортой байдалд ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг тул санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь улс орны хөгжил, тэр дундаа банк, санхүүгийн салбарын өсөлтөд томоохон үүрэг гүйцэтгэдэг юм.



ЗОХИЦУУЛАЛТЫН СЭНДБОКС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР

Өнөө үед ухаалаг гар утасны хэрэглээний өсөлт болон мэдээллийг боловсруулах шинэ үр дүн бүхий аргууд бидний амьдралд нэвтэрснээр санхүүгийн салбарт инновацийг нутагшуулах нөхцөл, суурийг бий болгоод байна. Санхүүгийн зах зээлд 2014 оноос

“Финтек” – санхүүгийн уламжлалт үйлчилгээг хүргэх инновацийн шийдлүүдийн талаар яригдаж эхэлсэн.

Цахим худалдааны талаарх бидний ойлголтыг Amazon, Aliexpress нар өөрчилсөн бол AirBnb-г үүсгэн байгуулагч нар үр

дүнтэй, эрсдэл багатай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн зах зээлийг бий болгож, харин Uber болон Яндекс такси нар нь таксины үйлчилгээг танигдахын аргагүй болтол нь өөрчлөөд байна. Үүнтэй нэгэн адилаар санхүүгийн зах зээлд crowdfunding, P2P

зээл гэх мэт цоо шинэ бизнесийн загварууд, хэрэглэгчтэй харилцах шинэ механизмууд (технологид суурилсан тусгай операторын тусламжтайгаар) бий болсноор хэрэглэгчийн хүлээлт болон хандлага огцом өөрчлөгджээ.

Гэвч санхүүгийн зах зээлийн зохицуулалтууд нь технологийн шинэчлэлийг хурдан хугацаанд хүлээн авч, өөрчлөгдөхөд төдийлөн бэлэн бус байдаг байна.

Шинэ бизнесийн загвар, бүтээгдэхүүн болон үйлчилгээг бий болгох нь олон удаагийн оролдлого, туршилтын арга дээр суурилдаг. Цорын ганц зөв шийдлийг олохын тулд компаниуд олон зуун аргачлалыг туршдаг билээ. Үүний үр дүнд өнөөг хүртэл өөрийн уян хатан чанараа алдаагүй хяналт, зохицуулалтууд нь шинэчлэлийг хийгчид буюу инновацийн компаниудад асар их эрсдэлийг авчирдаг. Инновацийн компаниудын технологийн шинэчлэлийн дүнд санхүүгийн уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулагдсан хяналт, зохицуулалтын хүрээнд тогтоосон хэм хэмжээ зөрчигдсөнөөс тэдгээр нь зохицуулагчийн зүгээс холбогдох арга хэмжээ авахуулах эрсдэлтэй учирдаг. Учир нь эдгээр зохицуулалтуудыг боловсруулах үед орчин үеийн технологи, бүтээгдэхүүн, бизнесийн загвар аль аль нь байгаагүй.

Тэгэхээр зохицуулагчид хүндхэн сорилтын өмнө хүрч ирээд байна. Тэрээр технологийн шинэчлэл бүрд эрх зүйн орчинг өөрчлөх боломжгүй ба нөгөө талаас зах зээлийг хяналтгүйгээр орхиж бас болохгүй. Зах зээлийг хяналт, зохицуулалтгүйгээр орхих нь эргээд санхүүгийн тогтвортой байдал, эсхүл хэрэглэгчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлдөг. Энэхүү асуудлын хамгийн шинэлэг болон ирээдүйтэй шийдлүүдийн нэг нь зохицуулалтын сэндрокс (regulatory sandbox) юм.

Зохицуулалтын сэндрокс гэдэг нь инновацийн компаниудад өөрсдийнхөө бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал эрх зүйн орчинд буюу холбогдох хууль, журмыг зөрчих эрсдэлгүйгээр турших боломжийг олгож буй тухайлсан багц дүрмүүд юм.

Их Британи, Сингапур, Австрали, Арабын Нэгдсэн Эмират (Абу-Дабигийн олон улсын санхүүгийн төв) зэрэг улсуудад хэрэгжиж буй, эсхүл төслийн хэмжээнд хэлэлцэгдэж буй зохицуулалтын сэндрокс-д судалгааг хийхэд, дараах дүгнэлтүүдийг судлаачид

гаргасан байна. Үүнд:

- Зохицуулалтын сэндрокс-г бий болгох санаачилгыг тухайн орны зохицуулагч байгууллагын зүгээс гаргадаг тул хувийн секторын оролцоо хязгаарлагдмал байдаг. Их Британи улсад төрийн зохицуулалтын сэндрокс дээр нэмэлт хэлбэрээр байгуулахыг зах зээлд оролцогчдод санал болгосон байна. Харин Австрали улсад зах зээлд оролцогчдын мэргэжлийн холбоодуудад тухайн компанийг туршилт, үйл ажиллагаанд оруулах эрхийг нь олгожээ.
- Зохицуулалтын сэндрокс нь зах зээлд оролцогч мэргэжлийн компаниудаас гадна ерөнхийдөө стартап, эсхүл зохицуулалтын хүрээнд хамааралгүй хуулийн этгээдэд нээлттэй байна. Өөрөөр хэлбэл тэдгээрийн аль алиных нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал эрх зүйн орчинд турших боломжтой.
- Ихэнх тохиолдолд тухайн оронд нэг бус, харин олон тооны зохицуулалтын сэндроксийг холбогдох төсөл бүрт бий болгосон байна. Зохицуулагч нь туршилтын нөхцөлүүдийг туршилтад оролцогч компани бүртэй тусгайлан тохиролцдог байна.
- Зохицуулагч нь сэндрокс-д оруулах төслийг маш анхааралтай сонгон шалгаруулдаг. Учир нь зарим компани эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох эцсийн зорилтын оронд тухайн бүтээгдэхүүний бизнесийн арилжааны үнэлгээг хэрэгжүүлэх замаар сэндроксоор олгосон эрх зүйн хязгаарлагдмал боломжийг урвуулан ашиглах боломж бий. Тиймээс компанийн зүгээс өөрийн бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээгээ тестлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага, мөн өөрийн инноваци шийдлийн үндэслэлийг зохицуулагчид батлан харуулах шаардлагатай.
- Эдүгээ дэлхий даяар зохицуулалтын сэндрокс-д тавигдах хязгаарлалт, шаардлага, шалгуурын нэгдсэн нэг аргачлал одоогоор алга байна. Учир нь төсөл бүрд тусгайлсан аргачлал, шаардлага тавигддаг тул нийтлэг зарчмыг тогтоох нь зохисгүй юм. Тухайлбал, дараах зарим хязгаарлалтыг хэрэгжүүлдэг: хэрэглэгчийн тооны дээд хязгаар, компанийн харилцагчийн өмнө

хүлээх үүргийг хамгийн дээд хэмжээнд хүргэх, мэдээллийн ил тод байдлыг тусгай байдлаар хангуулах болон бусад.

- Зохицуулалтын сэндроксийн давуу талууд гэвэл мөн тухайн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байна. Зарим тохиолдолд туршилтад оролцогч компани зохицуулалтын хүрээнд тавигддаг нөхцөл, шаардлагуудаас бүрэн чөлөөлөгдсөн байдаг. Гэвч ихэнх тохиолдолд зохицуулагч нь ач холбогдолгүй, эсхүл дарамт болсон, шаардлагагүй гэж үзсэн зарим дүрэм, журмын нөхцөл, шаардлагуудыг хэсэгчлэн чөлөөлдөг. Заримдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын нөхцөл, шаардлагыг газар дээр нь шинэчлэн сайжруулах асуудал хөндөгддөг байна.
- Зохицуулалтын сэндроксийн туршилтын хугацааг дунджаар 6–12 сараар тооцдог байна. Зарим тохиолдолд (АНЭУ) хоёр хүртэл жилээр туршилтын хугацааг тооцдог аж. Туршилтын хугацаа дуусмагц компани нь тухайн бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах (холбогдох зөвшөөрлийг олгож, бүртгэгдсэнээр), эсхүл тестээ зогсооно. Туршилтын хугацаанд оролцогч компани тестийн үйл явцын талаар зохицуулагчид мэдээлдэг.
- Зохицуулалтын сэндроксыг түүний онцлогоос нь хамаарч “зохицуулалтын үйлчилгээ” гэсэн өргөн утгаар нь нэрлэх боломжтой. Энэ үйлчилгээ нь эрх зүйн зохицуулалтыг тухайлан зөөлрүүлэхээс хальж, зөвлөх үйлчилгээ болон мэдээллийн дэмжлэг үзүүлэх, зах зээлд шинээр оролцогчдыг сургах зэргийг хамарч байна. Зохицуулагч нь инновацийн компанийн зөвлөх болох ба энэ үйл явцын хүрээнд тэрээр цаашид эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх зорилгоор зах зээлийн хандлагыг илүү сайн ойлгож эхэлдэг байна.


Зохицуулалтын сэндроксыг төслүүдийг боловсруулж буй улс орнуудын тоо гарын арван хуруунд багтах бөгөөд тестийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан орны тоо түүнээс ч бага юм. Гэвч улс орнуудын олж авсан анхны туршлага нь хамгийн үнэ цэнэтэй бөгөөд цаашид хэдэн арван жилийн туршид хэрэгжүүлэх хамгийн сайн практик үйл ажиллагааны суурь болох магадлалтай.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 245.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Нийт арилжааны үнийн дүнг бүтцээр нь авч үзвэл хувьцааны арилжаа 85.7 хувь, ЗГҮЦ–ны хоёрдогч зах зээлийн арилжаа 13.6 хувь, компанийн бондын зах зээлийн арилжаа 0.7 хувийг тус тус бүрдүүлж байна.


Зураг 6: Нийт арилжааны бүтэц/бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны арилжаа: Тайлант жилд МХБ болон МҮЦБ – ээр дамжуулан нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь өмнөх жилийн мөн үеийн дүнгээс 132.2 тэрбум төгрөгөөр өссөн. Энэхүү дүн нь хувьцааны арилжааны түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий арилжаа болсон билээ.


Зураг 7: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗГҮЦ–ны арилжаа: Тайлант хугацаанд ЗГҮЦ–ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. ЗГҮЦ–ны хоёрдогч зах зээлд 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр арилжсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийн ЗГҮЦ–ны хоёрдогч зах зээлийн арилжааны дүнтэй харьцуулахад 108.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Харин нийт дүнтэй харьцуулахад 739.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Зураг 8: Засгийн газрын үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Компанийн бондын арилжаа: Тайлант хугацаанд компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар 100 мянган ширхэг бондыг 1 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 12.9 мянган ширхэг бондыг 697.6 сая төгрөгөөр тус тус арилжаалав.

Зураг 9: Компанийн бондын арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа: 2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2018 оны 4 дугаар улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон. Үүнд:

ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, мал бэлтгэл, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адуу болон үхрийн, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилагддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг. Тайлант улиралд Хөдөө аж ахуйн биржээр нийт 711.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий ямааны ноолуур, хонины ноос,

тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр арилжаалагдсан бөгөөд нийт арилжааг бүтцээр ангилан үзвэл 83.1 хувийг ямааны ноолуур, 8.4 хувийг завод ноос, 7.9 хувийг хонины ноос 0.6 хувийг тэмээний ноос, 0.1 хувийг бодын хөөвөр тус тус эзэлж байна.

Зураг 10: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/



Зураг 10: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны болон давхар даатгалын нийт 23 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын

үндсэн дээр хийгдэж байгаа билээ. Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас ердийн даатгал 175.5 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 98.2 хувь, урт хугацааны даатгал 1.4 тэрбум төгрөг буюу

0.8 хувь, давхар даатгал 1.7 тэрбум төгрөг буюу 1 хувийг бүрдүүлэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 57.1 тэрбум төгрөг буюу 98.1 хувь, урт хугацааны даатгал 559.3 сая төгрөг буюу 1 хувийг, давхар даатгал 521.9 сая төгрөг буюу 0.9 хувийг эзэлж байна.


Зураг 11: Даатгалын хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Албан журмын даатгал: Манай улсад энэхүү даатгалын бүтээгдэхүүн 2012 оноос бий болсон бөгөөд албан журмын даатгалын нэг бүтээгдэхүүн үйлчилгээ байгаа нь жолоочийн албан журмын хариуцлагын даатгал юм.

Зураг 12: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тус даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөр болон хураамжийн орлогын харьцаа 2016 оноос эхлэн харьцангуй тогтворжих төлөвтэй байгаа ба сүүлийн 5 жилийн дунжийг авч үзвэл 56 хувь байгаа юм. Харин тайлант улиралд дунджаас ялимгүй доогуур 51.7 хувийн үзүүлэлттэй байлаа.

Даатгалын зуучлагчид: Тайлант онд даатгалын зуучлагчид нийт 66.2 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын бүтээгдэхүүнийг зуучилж, зуучилсан даатгалын хураамжийн орлогын дүн 48.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 14.3 хувиар өссөн үзүүлэлт байлаа.

Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн онд 7.1 тэрбум төгрөг байсан бол тайлант онд өмнөх оноос 2.2 тэрбум төгрөг буюу 31.3 хувиар өсөж 9.4 тэрбум төгрөгт хүрэв.

Зураг 13: Зуучилсан даатгалын нийт хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Даатгалын зуучлагчдын хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хөрөнгийн даатгал, зээлийн даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нь нийт зуучилсан хураамжийн орлого болон зуучлалын шимтгэлийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.

Харин сүүлийн жилүүдэд бусад даатгалын

бүтээгдэхүүн, тэр дундаа гэнэтийн осол эмчилгээний даатгал, агаарын хөлгийн даатгалын зуучлалын зах зээлд эзлэх хувь өсөх төлөвтэй байна. Тухайлбал 2018 онд зуучилсан даатгалын хураамжийн орлогын 4.6 хувийг гэнэтийн осол эмчилгээний даатгал, 2.8 хувийг агаарын хөлгийн даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын хохирол үнэлэгчид: Тайлант оны даатгалын хохирол үнэлгээний орлогын бүтцийг авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 52.4 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 25.6 хувь, хөрөнгийн даатгал 10.3 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 14: Даатгалын хохирол үнэлгээний орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагууд зээл, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад

валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх, факторингийн үйлчилгээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үндсэн үйл ажиллагаа гэсэн үндсэн 10 үйл ажиллагааг тусгай

зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байна. Эдгээр үйл ажиллагаанаас зээлийн үйл ажиллагааг нийт 492 банк бус санхүүгийн байгууллага, гадаад валютын арилжааг 157 банк бус санхүүгийн байгууллага дагнан болон бусад төрлийн үйлчилгээтэй хавсран эрхэлж байна.


Зураг 15: ББСБ-уудын тоо /үйлчилгээний төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого: 2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого 259.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт орлогын 96.7 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 83.8 хувь буюу 217.4 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 12.9 хувь нь буюу 33.5 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.

Зураг 16: ББСБ-ын салбарын нийт үйл ажиллагааны орлого /төрлөөр/



Хүүгийн бус орлогын 12.6 хувийг гадаад валютын арилжааны орлого, 26.2 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 4.0 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.5 хувийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 39.6 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 16.5 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 279 ХЗХ хадгаламж, зээлийн гэсэн үндсэн үйл ажиллагаа эрхлэхээс гадна нэмэлтээр төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ, даатгалын төлөөлөгчийн үйлчилгээг эрхлэн явуулж байна. Тайлант онд төслийн санхүүжилтийн үйлчилгээ эрхэлж буй 113 ХЗХ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхэлж буй 3 ХЗХ, даатгалын төлөөлөгчийн үйлчилгээ эрхэлж буй 3 ХЗХ байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 31.2 хувиар өсөж 39.6 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хүүгийн орлогын 92.5 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна. Түүнчлэн хүүгийн орлогыг бүрдүүлэгч зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого өнгөрсөн оноос 27.2 хувиар буурч 239.5 сая төгрөгт хүрсэн бол банк санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 94.0 хувиар өсөж 2.7 тэрбум төгрөг, санхүүгийн түрээсийн орлого 245.0 мянган төгрөг хүрчээ. Харин хүүгийн цэвэр орлого өнгөрсөн оноос 17.7 хувиар өсөж тайлант онд 16.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 17: ХЗХ-ны салбарын хүүгийн орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо /үйл ажиллагааны төрлөөр/

Үйл ажиллагаа	ХЗХ-дын тоо
Хадгаламж, зээл	279
Төслийн санхүүжилтийн үйлчилгээ	113
Санхүүгийн түрээсийн үйлчилгээ	3
Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа	3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 42.9 хувиар өсөж 23.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хүүгийн зардлын 97.7 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна. Мөн хүүгийн зардлын 1.9 хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал өмнөх оноос 21.7 хувиар өсөж 448.7 сая төгрөг болсон бол санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 25.9 сая төгрөгт хүрсэн нь хамгийн өндөр өсөлт буюу 156.2 хувиар өсжээ.

ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ /SWISS RE/

“Swiss re” давхар даатгалын компанийн гаргасан эдийн засгийн болон даатгалын зах зээлийн хэтийн төлөвийн талаарх тайланд эдийн засгийн өсөлт эерэг боловч хурд нь саарч буйтай холбоотойгоор даатгалын зах зээлийн жилийн хураамжийн орлого ирэх 2 жилд ердөө 3 хувиар өсөх хандлагатай, 2018 оноос 2019 онд 1%-ийн өсөлт үзүүлэхээр таамаглагдсан байна. Ихэнх эрэлт нь Азийн хөгжиж буй орнуудаас хамаарах төлөвтэй байгаа бөгөөд хураамжийн орлого нь дэлхий нийтийн дунджаас 3 дахин өндөр өсөлт үзүүлэхээр хүлээгдэж байна. Даатгалын зах зээл дэх шинэчлэлт нь даатгалд хамрагдах боломж, хамрах хүрээг нэмэгдүүлэх ба цаашлаад хураамжийн орлогыг нэмэгдүүлэх болно. Хөгжиж буй орнуудын зах зээл нь урт хугацааны болон ердийн даатгалын хувьд гол хөдөлгөгч хүч хэвээр байх болно, ялангуяа Хятадын зах зээлд.


Ердийн даатгалын зах зээлийн хувьд: 2018 онд ердийн даатгалын зах зээлийн хураамжийн орлого 3%-иар өснө хэмээн таамаглаж байсан бөгөөд дараагийн 2 жилд ч мөн ижилхэн байна гэж таамаглаж байгаа аж.

Дэлхий дахинд ердийн даатгалын зах зээлийн нийт хураамжийн орлого нь хөгжиж

буй орнуудын зах зээлийн нөлөөгөөр 2019 болон 2020 онд ойролцоогоор 8%-ийн өсөлттэй байна хэмээн таамаглаж байна.

Энэ жил эдийн засгийн хүчтэй өсөлтөөс шалтгаалан хөгжингүй орнуудын даатгалын хураамжийн орлогын хэмжээ ойролцоогоор 2 хувиар өссөн байна.

Зураг 18. Олон улсын ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт, өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага



Эх сурвалж: Swiss Re Institute

2019 онд андеррайтингийн үнэлгээ одоогийн түвшиндээ тогтвортой хэвээр байна гэсэн хүлээлттэй байна. 2018 онд эд хөрөнгийн даатгалын тохиолдлууд нэмэгдсэн нь байгалийн гамшиг ихтэй бүсүүдээс голчлон хамаарсан бөгөөд энэ шалтгааны улмаас гарах хохирол буурна гэсэн хүлээлттэй байна. Урт хугацааны даатгалын зах зээлийн хувьд: Дэлхий дахинд урт хугацааны даатгалын нийт хураамжийн орлого нь 1.6%-иар өсөх


бөгөөд энэ нь сүүлийн таван жилийн дундаж өсөлтөөс бага зэрэг саарсан үзүүлэлт юм.

2019, 2020 онд хөгжиж буй орнуудын хураамжийн орлогын өсөлт хурдсаж ойролцоогоор 9%-д хүрнэ гэж таамаглаж байна.

Хөгжингүй орнуудын урт хугацааны даатгалын хураамжийн орлого нь одоогийн түвшиндээ тогтвортой хэвээр байхаар таамаглагдаж байна.

ашиглан мэдээллийг цаг тухайд нь зардал багатайгаар олж авснаар өрсөлдөх чадвараа ч нэмэгдүүлэх боломжтой юм. Оvum хэмээх технологийн судалгааны компанийн судалгаанд дурьдсанаар даатгалын компаниуд зарим чухал үйлчилгээг SaaS хэмээх програм хангамжийн тусламжтайгаар шийдвэрлэдэг болсон байна. Жишээлбэл: АНУ-ын даатгагчдын хувьд SaaS системээр хүлээн авсан нэхэмжлэлийн хувь 2016 оноос 2018 онд 13 хувиас 26 хувь болж өссөн байна. Энэхүү чиг хандлагаас харахад шинэ технологийг хөгжүүлэгчид нь уламжлалт системээс хиймэл оюун ухаан гэх мэт шинэлэг хувилбарт илүү хөрөнгө оруулалт хийх хандлагатай байна. Үүлэн системд(cloud) шилжихэд төлөвлөлт, менежмент, ур чадвараа дээшлүүлэх шаардлага үүсэж байна. Мөн цаашид компанийн хүний нөөцөө ч энэ технологийн дэвшилд нийцүүлэн бэлдэх цаашлаад шинээр ажилд авч буй хүмүүстээ ч ийм шаардлага тавихад хүргэж байна.

Зураг 19. Олон улсын урт хугацааны даатгалын хураамжийн орлогын өсөлт, өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага



DELOITTE

Эдийн засгийн анхаарал татсан хэсгүүд: 2018-аас 2019 онд даатгагчдын хувьд сайн жил байсан бол 2020 онд эдийн засгийн удаашралтай холбоотой зарим асуудлууд нэмэгдэж байна. Ихэнх нь АНУ ба Хятадын хоорондох маргаантай асуудал шиг бусад орнуудын өндөр татвар, худалдааны дүрэм журмуудын талаар одоогийн байдалд санаа зовниж байна. Үүний зэрэгцээ, татварын хөнгөлөлт болон засгийн газрын хэрэглээг бууруулах замаар 2020 онд эдийн засгийг сэргээх хүлээлттэй байна харин бодлогын хүүгийн өсөлт нь хэрэглэгчдийг зээл авах, орон сууц барих болон бизнесээ өргөжүүлэх боломжийг багасгаж болзошгүй юм. Жишээлбэл, дэлхийн хөрөнгө оруулалтын томоохон компаниудын нэг болох Vanguard нь 2020 оны сүүлээр эдийн засгийн

уналт 30 хувиас 40 хувь байх боломжтойг анхааруулсан. Үүний нэг илрэл бол түүхэнд бодлогын хүүний богино болон урт хугацааны өгөөжийн муруй буурах нь эдийн засгийн хямралыг урьдчилан таамаглаж байсныг эдийн засагчид дурдсан байна. Түүнчлэн даатгагчид одоогийн хэвийн өсөлтөө хадгалахын тулд шинээр гарч ирж буй дижитал эдийн засгийн хэрэгцээ шаардлагад тохируулан бүтээгдэхүүн үйлчилгээг өөрчлөхийн зэрэгцээ үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, шинэ технологийг ашиглан зардлаа багасгахад анхааран, хянамгай болж байна.

Шинэ технологийг хөгжүүлэгчид нь тус салбарын онцлогт тохирсон технологийн шийдлийг илүү ахисан түвшинд хөгжүүлэн санал болгож байна. Энэхүү системийг

Даатгал 2020: Чимээгүй хувьсгал – Олон улсын даатгалын зах зээлийн ирээдүй /PWC/ Санхүүгийн мэргэжлийн үйлчилгээгээрээ олон улсад хоёрдугаарт жагсдаг PWC/PricewaterhouseCoopers/-ийн мэдээлснээр олон улсын даатгалын зах зээл сайжрах төлөвтэй байна. Ази болон Латин Америкийн хөгжиж буй зах зээлүүд өсөж хөгжихийн зэрэгцээ Европ ба Хойд Америкийн хөгжингүй эдийн засгууд сэргэж байна. Дэлхий дахины хураамжийн орлогын хүлээлт нь хэдий таамаглал ч гэлээ тус салбарын өгөөж нь хуучных шигээ байхгүй. Даатгалын компани нь урт хугацааны зорилгодоо хүрэхэд хэцүү нөхцөл байдалд үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгагчид нь хөрөнгө оруулалтын бага өгөөжтэй, хатуу зохицуулалттай, эрэлтээсээ давсан нийлүүлэлт зэрэг саад бэрхшээлтэй нүүр тулгарч байна. Даатгагчид бизнесийн загварчлалаа энэхүү шинэ орчинд тохируулахад M&A-ийн стратегийн ач холбогдол улам нэмэгдэж байна.

2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

4 ДУГААР САРЫН 10,11

СХН болон Жи24-ийн Бодлого боловсруулагчдын ээлжит дугуй ширээний уулзалт, АНУ

5 ДУГААР САРЫН 13-17

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын 44 дүгээр ээлжит чуулга уулзалт, Үндэстнүүдийн Холбооны Австрали Улс

5 ДУГААР САРЫН 29-31

Бичил санхүүгийн төв (МФС) ээлжит чуулган, Бүгд Найрамдах Турк Улс

6 ДУГААР САРЫН 17-20

СХН-ийн Зүүн Европ Төв Азийн Зөвлөлийн Уулзалт

6 ДУГААР САРЫН 29

Азийн ИншурТек дээд уулзалт, Бүгд Найрамдах Сингапур Улс

7 ДУГААР САРЫН 24-26

Олон улсын хоршоодын зохицуулагчдын сүлжээ (ICURN)-ний ээлжит чуулган АНУ

9 ДУГААР САРЫН 9-13

СХН-ийн ээлжит Дэлхийн бодлогын форум, Руандагийн Бүгд Найрамдах Улс



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо